



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.09 № 03/538

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/234 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн НХААГ/20240101231 дугаартай Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо) ажлын тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Захиалагчийн тодруулгын хариу
1	Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана” гэсэн байна. Хэрвээ тухайн тендер шалгаруулалтад оролцогчийн зүгээс санал болгож байгаа инженер, техникийн ажилтнуудаас зарим нь 1970 - 1990 онуудад тухайн үеийн БНМАУ-д их дээд сургууль төгссөн дипломтой, дээд боловсролын дипломын мэдээлэл нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-Mongolia/-с гарч ирэхгүй байгаа тохиолдолд хэрхэх вэ? Тухайн ажилтны дээд боловсролын дипломын нотариатаар батлуулсан хуулбарыг тендертээ хавсаргасан тохиолдолд шаардлага хангах уу?	Шаардлага хангахгүй. Ажилтан дээд боловсролын сургалтын байгууллагыг 2019 оноос өмнө төгссөн, түүний дипломын мэдээлэл Төрийн үйлчилгээний E-Mongolia цахим систем дээр бүртгэлгүй бол Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэдээллийн технологи, статистикийн хэлтэст хандан өргөдөл гарган дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгүүлнэ. Хэрхэн бүртгүүлэхийг хавсралтаар хүргүүлж байна.

Тодруулгын хариуг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалтын дагуу цахим системд нээлттэй байршуулж байна.

Хавсралт 1 хуудастай.